

МОНГОЛ УЛСЫН ТӨМӨР ЗАМЫН СҮЛЖЭЭНД ГАЛТ ТЭРЭГ ДУГААРЛАХ ЗААВАР

Нэг. Нийтлэг үндэслэл:

Бүс нутаг болон бүс нутаг дахь төрийн өмчит, хувийн хэвшлийн дэд бүтэц эзэмшигч, ашиглагчийн найруулсан дамжуулах, хэсгийн, түүвэр, зөөврийн галт тэрэгнүүдийг хооронд нь ялгах, галт тэрэг дугаарлалтыг давхардуулалгүй нэгдсэн дугаарлалттай болгох Монгол улсын төмөр замын сүлжээний хэмжээнд галт тэрэгний дугаарлалт олгохтой холбоотой харилцааг зохицуулна.

Хоёр. Ачааны галт тэрэгний ангилал

2.1. Ачааны галт тэргийг доорх байдлаар ангилна.

- а. Хүрэх өртөөгөөр
- б. Ачаатай, хоосон, холимог

2.2. Ачааны өртөөдөд найруулсан галт тэрэгнүүд дараах төрлүүдэд хуваагдана. Үүнд:

Бүсийн - Бүс дотроо аялаж буй бүх төрлийн галт тэрэг.

Шууд - Хэсгийн өртөөд болон дэд бүтцээр ажиллагаа хийгдэхгүй өнгөрөх галт тэрэг.

Хэсгийн - Нэг техникийн өртөөнөөс дараагийн техникийн өртөө хүртэл зам зуурт ажиллагаа хийгдэхгүй өнгөрөх галт тэрэг.

Түүвэр - Нэг хэсгийн хэд хэдэн завсрын өртөөнд зогсож ажиллагаа хийх, нэг хэсгийн хэд хэдэн өртөөдөд хаягтай вагонуудаар найруулагдсан галт тэрэг.

Зөөврийн - Хэсгийн болон завсрын өртөөнөөс тулгуур өртөө болон түүний үйлчилдэг өртөөнд хүрэх вагоноор найруулагдсан галт тэрэг.

Дамжуулах - Нэг бүсээс нөгөө бүсэд, эсвэл нэг улсаас нөгөө улсад очих галт тэрэг

ДНЦ-ийн мэдлийн зүтгүүр - Галт тэрэгний диспетчерийн шийдвэрээр тухайн хэсгийн болон завсрын өртөөдөд вагон хүргэх, ачилт буулгалтын фронтод тавих, татаж авч хэсгийн ба ялгалтын өртөөдөд хүргэх зүтгүүр.

2.3. Галт тэргэнд найруулагдсан вагонуудыг ачаатай, хоосон байдлаар ангилна. Үүнд:

Ачаатай вагон бүхий галт тэрэг /ачаатай вагонуудаас бүрдсэн галт тэрэг/

Хоосон вагон бүхий галт тэрэг /хоосон вагонуудаас бүрдсэн галт тэрэг/

Холимог вагон бүхий галт тэрэг /Ачаатай болон хоосон вагонуудаас бүрдсэн галт тэрэг/

Гурав. Ачааны галт тэрэгний жин болон урт

3.1. Галт тэрэгний жин болон уртын хэмжээг тухайн бүс нутгийн онцлог, бүс нутаг дахь дэд бүтэц эзэмшигч, ашиглагчдын дотоод журмаар тогтоох боловч өөр бүс рүү дамжуулах галт тэргийг найруулахдаа дэд бүтэц эзэмшигч, ашиглагч болон бусад бүстэй хийсэн галт тэрэг солилцоо, хамтын ажиллагааны гэрээний дагуу найруулна.

3.2. Галт тэрэгний жингийн хугарал хийгддэг өртөөдөд галт тэргэнд вагон холбохдоо галт тэрэг найруулах төлөвлөгөөний дагуу бүс, чиглэл, ачааны нэр төрлөөр бүлэглэн найруулна.

3.3. Хоногийн ажлын төлөвлөгөө боловсруулахдаа хүнд жинтэй болон урт бүрэлдэхүүнтэй галт тэрэг тусгах бол галт тэрэгний хөдөлгөөний удирдлагын журмын дагуу тэмдэглэгээ хийнэ.

3.4. Шууд, дамжуулах галт тэрэгнээс техникийн болон ачаа тээврийн зөрчлөөр салгагдсан вагоныг тээвэрлэхэд бэлэн болсон, галт тэрэгний урт, жингийн хугарлаар салсан вагонуудыг галт тэргэнд холбохдоо галт тэрэг найруулах төлөвлөгөөний дагуу найруулж явуулна.

Дөрөв. Галт тэрэгний дугаарлалт

4.1. Монгол улсын төмөр замын сүлжээнд аялаж буй галт тэрэг бүр ангилалаасаа хамаарч дугаарлагдана. Төмөр замын сүлжээг төвийн болон зүүн, баруун, өмнөд гэсэн 4 бүсэд хуваана.

- I. Төвийн бүсийн - Хойт зөрлөгөөс Замын-Үүд чиглэлийн дагуух төмөр замууд;
- II. Өмнөд бүсийн - Сайншандаас Нарийн сухайт чиглэлийн дагуух төмөр замууд;
- III. Зүүн бүсийн - Эрээнцаваас Сайншанд чиглэлийн дагуух төмөр замууд;
- IV. Баруун бүсийн - Нарийн сухайтаас Арц суурь чиглэлийн дагуух төмөр замууд.

4.2. Төмөр замын 4 бүсийг англи цагаан толгойн том үсгийг ашиглан дараах байдлаар тэмдэглэнэ.

- I. Төвийн бүс – **C**
- II. Өмнөд бүс – **S**
- III. Зүүн бүс – **E**
- IV. Баруун бүс – **W**

4.3. Бүс нь дотроо хэд хэдэн дэд бүтэц, хэсэглэлтэй байж болно. Бүсэд оноогдсон дугаарлалтыг тухайн бүс нь дэд бүтцүүддээ хуваарилана.

4.4. Галт тэрэгнүүдийг дараах байдлаар ангилж дугаарлалт олгоно.

4.4.1. Зорчигчийн галт тэрэг:

4.4.1.1. **1-499.** Олон улсын, жуулчны, орон нутгийн зорчигчийн галт тэрэг

4.4.1.2. **501-699.** Ачаа зорчигчийн галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 601-649
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 651-699
- III. Зүүн бүсийн төмөр зам - 501-549
- IV. Баруун бүсийн төмөр зам - 551-599

4.4.1.3. **801-899.** Хүмүүсийн галт тэрэг (ачааны бичиг баримтаар яваа) ба цэргийн цуваа

- I. Төвийн бүсийн төмөр зам - 801-829
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 831-849
- III. Зүүн бүсийн төмөр зам - 851-869
- IV. Баруун бүсийн төмөр зам - 871-899

4.4.1.4. **961-999.** Тусгай галт тэрэг (цагийн хуваарьт тусгагдаагүй зорчигчийн галт тэрэг)

- I. Төвийн бүсийн төмөр зам - 961-969
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 971-979
- III. Зүүн бүсийн төмөр зам - 981-989
- IV. Баруун бүсийн төмөр зам - 991-999

4.4.2. Ачааны хурдан галт тэрэг:

4.4.2.1. **1001-1040.** Хөргүүрт вагоноос бүрдсэн тусгай зориулалтын ачааны галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 1001-1009
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 1011-1019
- III. Зүүн бүсийн төмөр зам - 1021-1029
- IV. Баруун бүсийн төмөр зам - 1031-1039

4.4.2.2. **1101-1299.** Чингэлэг тээвэрлэх галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 1251-1299
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 1201-1249
- III. Зүүн бүсийн төмөр зам - 1151-1199
- IV. Баруун бүсийн төмөр зам - 1101-1149

4.4.2.3. **1301-1399.** Илгээгчийн замналын галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 1301-1329
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 1331-1349
- III. Зүүн бүсийн төмөр зам - 1351-1369
- IV. Баруун бүсийн төмөр зам - 1371-1399

4.4.2.4. **1401-1489.** Хялбар муудах ачаа тээвэрлэх галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 1401-1429
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 1431-1449
- III. Зүүн бүсийн төмөр зам - 1451-1469
- IV. Баруун бүсийн төмөр зам - 1471-1489

4.4.2.5. **1501-1579.** Адгуус тээвэрлэх галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 1501-1519
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 1521-1539
- III. Зүүн бүсийн төмөр зам - 1541-1559
- IV. Баруун бүсийн төмөр зам - 1561-1579

4.4.2.6. **1601-1799.** Засгийн газрын тушаалаар аялах ачааны галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 1601-1649
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 1651-1699
- III. Зүүн бүсийн төмөр зам - 1701-1749
- IV. Баруун бүсийн төмөр зам - 1751-1799

4.4.3. Дамжин өнгөрөх шууд галт тэрэг:

4.4.3.1. **2001-2199.** Улс хоорондын шууд нэвтрэх ачаа тээвэрлэх галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 2001-2049
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 2051-2099
- III. Зүүн бүсийн төмөр зам - 2101-2149
- IV. Баруун бүсийн төмөр зам - 2151-2199

4.4.3.2. **2201-2399.** Төмөр замын сүлжээний хэмжээнд дэд бүтэц хоорондын шууд дамжин өнгөрөх ачаа тээвэрлэх галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 2201-2249
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 2251-2299
- III. Зүүн бүсийн төмөр зам - 2301-2349
- IV. Баруун бүсийн төмөр зам - 2351-2399

4.4.4. Бүсийн доторх дэд бүтцийн галт тэрэг:

4.4.4.1. **2501-2999.** Хэсгийн өртөөнөөс дараагийн нэг ба хэд хэдэн хэсэгт ажиллагаа хийгдэхгүй галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 2501-2699
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 2701-2799
- III. Зүүн бүсийн төмөр зам - 2801-2899
- IV. Баруун бүсийн төмөр зам - 2901-2999

4.4.4.2. **3001-3699.** Хэсгийн галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 3101-3299
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 3001-3099
- III. Зүүн бүсийн төмөр зам - 3301-3499
- IV. Баруун бүсийн төмөр зам - 3501-3699

4.4.4.3. **3401-3499.** Түүвэр галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 3401-3429
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 3431-3449
- III. Зүүн бүсийн төмөр зам - 3451-3469
- IV. Баруун бүсийн төмөр зам - 3471-3499

4.4.4.4. **3501-3799.** Зөөврийн галт тэрэг (Завсрын өртөөдөд болон зэргэлдээ өртөө, салбар замд вагон тавьж өгөх, татаж авах)

- I. Төвийн бүсийн төмөр зам - 3501-3599
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 3601-3649
- III. Зүүн бүсийн төмөр зам - 3651-3699
- IV. Баруун бүсийн төмөр зам - 3701-3799

4.4.4.5. **3801-3999.** Галт тэрэгний диспетчерийн мэдлийн болон сэлгээний зүтгүүрээр хэсгийн, завсрын өртөөдөд вагон тавьж өгөх, татаж авах галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 3801-3849

- II. Өмнөд бүсийн төмөр зам - 3851-3899
- III. Зүүн бүсийн төмөр зам - 3901-3949
- IV. Баруун бүсийн төмөр зам - 3951-3999

4.4.5. Ганцаарчилсан зүтгүүрүүд:

4.4.5.1. **4001-4199.** Түлхэгч зүтгүүрүүд

- I. Төвийн бүсийн төмөр зам - 4101-4149
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 4001-4049
- III. Зүүн бүсийн төмөр зам - 4051-4099
- IV. Баруун бүсийн төмөр зам - 4151-4199

4.4.5.2. **4201-4299.** Тусламжийн зүтгүүр

- I. Төвийн бүсийн төмөр зам - 4201-4249
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 4251-4259
- III. Зүүн бүсийн төмөр зам - 4261-4279
- IV. Баруун бүсийн төмөр зам - 4281-4299

4.4.5.3. **4301-4399.** Дан зүтгүүрүүд

- I. Төвийн бүсийн төмөр зам - 4301-4349
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 4351-4359
- III. Зүүн бүсийн төмөр зам - 4361-4379
- IV. Баруун бүсийн төмөр зам - 4381-4399

4.4.5.4. **4401-4499.** Тээврийн бичиг баримттай яваа бүлэг зүтгүүрүүд

- I. Төвийн бүсийн төмөр зам - 4401-4449
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 4451-4459
- III. Зүүн бүсийн төмөр зам - 4461-4479
- IV. Баруун бүсийн төмөр зам - 4481-4499

4.4.5.5. **4901-4999.** Зүтгүүрийн депод засвар хийлгэхээр яваа гэмтэлтэй зүтгүүрүүд

- I. Төвийн бүсийн төмөр зам - 4901-4949
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 4951-4959
- III. Зүүн бүсийн төмөр зам - 4961-4979
- IV. Баруун бүсийн төмөр зам - 4981-4999

4.4.6. Туршилтын аялалд зориулсан галт тэрэг:

4.4.6.1. **5001-5049.** Зорчигчийн галт тэрэгний бүрэлдэхүүн, зүтгүүрийг турших

- I. Төвийн бүсийн төмөр зам - 5001-5019
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 5021-5029
- III. Зүүн бүсийн төмөр зам - 5031-5039
- IV. Баруун бүсийн төмөр зам - 5041-5049

4.4.6.2. **5051-5099.** Ачааны галт тэрэгний бүрэлдэхүүн, зүтгүүрийг турших

- I. Төвийн бүсийн төмөр зам - 5051-5059

- II. Өмнөд бүсийн төмөр зам - 5061-5069
- III. Зүүн бүсийн төмөр зам - 5071-5079
- IV. Баруун бүсийн төмөр зам - 5081-5099

4.4.7. Аж ахуйн галт тэрэг:

4.4.7.1. **5101-5199.** Хоорондын замд зүтгүүргүйгээр явах боломжтой өөрөө явагч техникүүд

- I. Төвийн бүсийн төмөр зам - 5101-5129
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 5131-5149
- III. Зүүн бүсийн төмөр зам - 5151-5169
- IV. Баруун бүсийн төмөр зам - 5171-5199

4.4.7.2. **5201-5299.** Зам засварын ажилд зориулан ачаа зөөвөрлөх аж ахуйн галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 5201-5229
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 5231-5249
- III. Зүүн бүсийн төмөр зам - 5251-5269
- IV. Баруун бүсийн төмөр зам - 5271-5299

4.4.7.3. **5301-5349.** Ус зөөврийн галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 5321-5329
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 5301-5309
- III. Зүүн бүсийн төмөр зам - 5331-5349
- IV. Баруун бүсийн төмөр зам - 5311-5319

4.4.7.4. **5401-5499.** Зам хэмжигч лабораторийн вагон

- I. Төвийн бүсийн төмөр зам - 5401-5429
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 5431-5449
- III. Зүүн бүсийн төмөр зам - 5451-5469
- IV. Баруун бүсийн төмөр зам - 5471-5499

4.4.8. Дамжуулах галт тэрэг:

4.4.8.1. **6001-6399.** Бүс хооронд дамжуулах галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 6001-6099
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 6101-6199
- III. Зүүн бүсийн төмөр зам - 6201-6299
- IV. Баруун бүсийн төмөр зам - 6301-6399

4.4.8.2. Хилийн өртөөд хооронд дамжуулах галт тэрэгний дугаарлалтыг Монгол, ОХУ, БНХАУ-ын төмөр замын байгууллагуудын төлөөлөгчдийн зөвлөгөөний протоколд тусгагдсаны дагуу мөрдөнө.

4.4.9. Сэргээн босгох, галын болон цас, элс цэвэрлэх галт тэрэг:

4.4.9.1. **8001-8039.** Сэргээн босгох галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 8001-8009

- II. Өмнөд бүсийн төмөр зам - 8011-8019
- III. Зүүн бүсийн төмөр зам - 8021-8029
- IV. Баруун бүсийн төмөр зам - 8031-8039

4.4.9.2. **8101-8139.** Галын галт тэрэг

- I. Төвийн бүсийн төмөр зам - 8101-8109
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 8111-8119
- III. Зүүн бүсийн төмөр зам - 8121-8129
- IV. Баруун бүсийн төмөр зам - 8131-8139

4.4.9.3. **8201-8239.** Цас, элс цэвэрлэгч

- I. Төвийн бүсийн төмөр зам - 8201-8209
- II. Өмнөд бүсийн төмөр зам - 8211-8219
- III. Зүүн бүсийн төмөр зам - 8221-8229
- IV. Баруун бүсийн төмөр зам - 8231-8239

Тав. Галт тэрэг дугаарлах аргачлал

5.1. Төмөр замын нэгдсэн сүлжээний галт тэрэгний дугаарын сүүлийн оронг (цифр) хойд зүгээс өмнө зүгт, зүүнээс баруун зүгт тэгш тоогоор, урд зүгээс хойд зүгт, баруун зүгээс зүүн зүгт сондгой тоогоор дугаарлана. Салаалсан замд явах галт тэргийг салж байгаа үндсэн өртөөнөөс эхлэн тэгшээр, эсрэг чиглэлд сондгой тоогоор дугаарлана.

5.2. Галт тэрэгний дугаарыг Улаанбаатарын цагаар 17:00 цагаас эхэлж шинээр дугаарлах бөгөөд 24 цагийн турш дугаарлалтыг давхардуулалгүй олгоно.

5.3. Бүсүүд дамжин аялах олон улсын, жуулчны болон орон нутгийн зорчигч тээврийн галт тэрэгний дугаарлалт өөрчлөгдөхгүй бөгөөд бүсийг тодотгосон үсгэн тэмдэглэгээ хийгдэхгүй.

5.4. Бүс дотороо аялах ачааны галт тэрэгний дугаарын урд бүсийг тодотгосон үсгэн тэмдэглэгээг хийхгүй.

5.5. Бүсийг хиллэж буй уулзварын өртөөн дээр дамжин өнгөрөх галт тэргийг дугаарлахдаа зохих дугаарын өмнө анх найруулсан бүсийн үсгэн тэмдэглэгээг нэмэлтээр бичиж аялалыг үргэлжлүүлнэ. (Ж.нь: **C2252**)

5.6. Хэрэв төмөр замууд нь бүсийн зааг дээр тус бүрдээ хилийн өртөөтэй бөгөөд дамжуулах галт тэрэгнүүдийг зөөвөрлөн хүргэдэг тохиолдолд энэхүү зааврын 4.4.8.1-т заасан дугаарыг олгоно. Дамжуулах галт тэрэгний дугаарын урд уг галт тэргийг анх найруулсан бүсийн үсгэн тэмдэглэгээг хийнэ. (Ж.нь: **W6001**)